

ҮНДЭСНИЙ ДАВХАР ДААТГАЛ ХК-ИЙН 2023 ОНЫ АВЛИГЫН
ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2023 оны 12 сарын 07-ны өдөр

Улаанбаатар хот

Д/д	Зорилго	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэлийн үзүүлэлт	Хугацаа	Биелэлт
1	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх	1.1.АТГ-аас бэлтгэсэн ТВ шторк, инфографик, видео график, нийтлэл, теле зохиомж, хөдөлгөөнт зураг, зурагт хуудас, цахим ном, гарын авлага зэргийг байгууллагын албан ёсны цахим хуудас болон нийгмийн сүлжээ (фейсбүүк, твиттер, youtube суваг) мөн сурталчилгааны самбарт байршуулах зэргээр иргэд олон нийтэд хүргэх	Баримтжуулж, үр дүнг тооцож, тайлагнасан байх	2023.01.02-2023.12.31	Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд бүтэн жилийн хугацаанд АТГ-аас бэлтгэсэн шторк, теле зохиомж, нийтлэл зэргийг байгууллагын цахим хуудас болон нийгмийн сүлжээнд нийт 46 төрлийн мэдээллийг байршуулан сурталчилав. Дэлгэрэнгүйг хавсралт №1 харна уу.
		1.3.Авлигын эсрэг үйл ажиллагааг мэдээлэн сурталчлах самбар байгуулах	Мэдээллийг тогтмол шинэчлэх ажлыг хэвшүүлсэн байх, АТГ-с ирүүлсэн мэдээллийг байршуулах	2023.02.01-2023.12.31	
		1.2.Авлигатай тэмцэх газраас санаачилсан аян, арга хэмжээг байгууллагад зохион байгуулах	Арга хэмжээг зохион байгуулж тайлагнасан байх	2023.01.02-2023.12.31	

					<p>нөхөн төлбөр олгох эсэх, компанийн эрсдэлийн удирдлагатай холбоотой бусад асуудлыг шийдвэрлэх чиг үүрэг бүхий Эрсдэлийн хорооны хурлаар хэлэлцэх асуудалд тус хорооны гишүүдээс "Ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл"-ийг тухай бүр гаргуулан АТГ-ын www.meduuleg.iaac.mn цахим хуудаст бүртгэн мэдээлдэг болсон.</p> <p>2023 оны 5 дугаар сараас эхлэн тайлан гаргах өдрийн байдлаар нийт 26 удаагийн мэдэгдлийг тус цахим хуудаст бүртгэн мэдээлэв.</p>
2	<p>Авлигын эсрэг сургалт зохион байгуулах, ажилтнуудаа АТГ-аас зохион байгуулсан сургалтад хамруулах</p>	<p>2.1. Авлигын эсрэг сургалтын санал, захиалгын төлөвлөгөөнд тусгуулахаар АТГ-ын УССГХ-т хүргүүлэх</p>	<p>Сургалтад хамруулах санал захиалга өгсөн байх</p>	<p>2023.03.25-ны дотор</p>	<p>2023.03.14-ний өдрийн 01/87 тоот албан бичгээр АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэст хаяглан сургалтын захиалгыг хүргүүлсэн.</p> <p>2023.10.26-ны өдрийн 01/275 тоот албан бичгээр Авлигатай тэмцэх газарт хаяглан Эрсдэлийн үнэлгээ хийх ойлголт өгөх сургалтын захиалгыг хүргүүлэв.</p> <p>Нотломжийг хавсаргав.</p>
		<p>2.2. АТГ-аас зохион байгуулдаг авлигын эсрэг анхан болон давтан сургалтад албан хаагчдаа хамруулах</p>	<p>Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо</p>	<p>2023.06 сар, 2023.11 сар</p>	<p>2023.03.31-ний өдөр АТГ-ын Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэсээс зохион байгуулдаг сургалт Үндэсний давхар даатгал ХК-ийн байранд зохион байгуулагдсан бөгөөд</p>

					сургалтад нийт 33 ажилтан хамрагдав. 2023.11.01-ний өдөр АТГ-ын Судалгаа шинжилгээний албаны ахлах ажилтан, ахлах комиссар Ц.Бадам Авлигын эрсдэлийн үнэлгээ хийх ойлголт, аргачлалын талаарх сургалт компанийн байранд зохион байгуулагдаж, тус сургалтад нийт 24 ажилтан хамрагдсан. Нотломжийг хавсаргав.
3	АТГ-аас бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шийдвэрийг биелүүлэх, хариуг хугацаанд нь мэдэгдэх	3.1.Авлигатай тэмцэх газраас хүргүүлсэн зөвлөмж 3.2.Мөрдөгчийн мэдэгдэл 3.3.Зөрчил арилгуулах албан бичгийн хүрээнд зохион байгуулах арга хэмжээ	Арга хэмжээг хэрэгжүүлэн хариу тайланг хүргүүлсэн байх	2023.01.02-2023.12.31	АТГ-ын 2023 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд нийтлэг байдлаар хэрэгжүүлбэл зохих арга хэмжээний саналын дагуу үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилласан. Тайлант хугацаанд зөрчил үүсээгүй.
4	Байгууллагын удирдлагын авлигатай тэмцэх хүсэл эрмэлзэл, санаачилга өрнүүлэх	4.1.Авлигын эсрэг төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн байгууллагаас гаргасан санал, санаачилга уриа, аянд нэгдэх 4.2.Төрийн байгууллага хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлцэлд авлигаас урьдчилан сэргийлэх асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах	Санал, санаачилга аянд нэгдэж, гэрээнд урьдчилан сэргийлэх заалт оруулсан байдал	2023.01.02-2023.12.31	Төрийн болон хувийн хэвшлийн байгууллагатай байгуулж буй аливаа гэрээ хэлцэлд ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хариуцлагажуулсан дараах агуулга бүхий заалтыг тусган оруулж байна. - “Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх болон гэрээний хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсгэхгүй байх үүрэгтэй бөгөөд ашиг сонирхлын зөрчил үүсгэх, үүсч болзошгүй нөхцөл байдал илэрсэн тохиолдолд нэн

					<p>даруй нөгөө талд албан ёсоор мэдэгдэн, шаардлагатай арга хэмжээг авч, харилцан зөвшилцөж, шийдвэрлэнэ.</p> <p>- Ашиг сонирхлын зөрчил нь гэрээний хэрэгжилт, биелэлт, үүргийн гүйцэтгэл, тухайн талын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлсөн тохиолдолд төрийн хяналт, шалгалтын байгууллагад хандан шалгуулах эрх, үүрэгтэй”</p> <p>- Захиалагчийн анхдагч зах зээлд үнэт цаас гаргахтай холбогдуулан энэхүү гэрээгээр тохирсон ажлыг гүйцэтгэх захиалгад Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, хэлэлцэх, бэлтгэх аль ч үе шатуудад Захиалагч, Гүйцэтгэгч бид Авлигын эсрэг хуулийг зөрчөөгүй болохоо илэрхийлэн баталж байна.</p>
5	Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах	5.1.Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэх /Үйлчилгээг цахимжуулах, шат дамжлага бууруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэлийн үнэлгээ хийлгэх гэх мэт/	Шинэ шийдэл, технологийг нэвтрүүлэх замаар хүнд суртал чирэгдлийг багасгах зэрэг үр дүнтэй арга хэмжээг зохион байгуулсан байх	2023.01.02-2023.12.31	Компанийн хэрэгжүүлдэг үндсэн үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэн.
6	Байгууллагын үйл ажиллагааг Авлигын эсрэг хуульд нийцүүлэх	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс	Хуулийн хэрэгжилтийг хангуулах	2023.01.02-2023.12.31	Тайлант хугацаанд Хавсран гүйцэтгэх албан тушаалын урьдчилсан мэдүүлгийг 2022.12.27-ны өдрийн 01/353 тоот

		урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Авлигатай тэмцэх газарт тухай бүр			албан бичгээр хүргүүлж АТГ-аас хариуг хүлээн авсан.
7	Авлигын эрсдэлийг тогтоох	Авлигын эрсдэлийн үнэлгээг хөндлөнгийн байгууллагаар хийлгэх	Авлигаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах	2023.01.02-2023.12.31	Авлигын эрсдэлийн үнэлгээг хийх хөндлөнгийн байгууллагыг сонгон шалгаруулах ажил 3 дугаар улиралд төлөвлөгдсөн байсан. 2023.09.13-ны өдөр АТГ-ын Судалгаа шинжилгээний албанаас эрсдэлийн үнэлгээ хийх мэргэжлийн шинжээчдийн мэдээллийг авахаар холбогдоход Эрсдэлийн шинжээч бэлтгэх сургалт зохион байгуулагдах гэж байгаа 11 сар гэхэд шинжээчид бэлтгэгдэх талаар мэдээлэл авсан. 2023.10.23-ний өдөр АТГ-ын тус албанаас бид шаардлагатай гэж үзсэн байгууллагад өөрсдийн төлөвлөгөөнд оруулан эрсдэлийн үнэлгээ хийдэг бөгөөд манай байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийх сургалт, арга зүйн зөвлөгөө өгч хамтран ажиллаж болох ба энэхүү ажиллагааг хөндлөнгийн этгээдээр хийлгэхэд өртөг өндөртэй байдаг учир байгууллага өөрийн жилийн үйл ажиллагааны төсөвт тусган байгууллага өөрсдөө эхний

					ээлжинд дотооддоо төлөвлөгөө гарган эрсдэлийн үнэлгээ хийхийг зөвлөсөн.
8	<ul style="list-style-type: none"> • Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 • Шилэн дансны тухай хуулийн 6.1, 6.4 • Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.9-д заасан болон • Холбогдох бусад мэдээллийг хариуцсан ажилтан тухай бүр байгууллагын үйл ажиллагааны болон хүний нөөцийн ил тод байдал, төсөв санхүүгийн ил тод байдлын мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд байгууллагын мэдээллийн самбар болон холбогдох бусад албан ёсны цахим хуудсанд байршуулж, иргэд олон нийт үзэж танилцах бололцоогоор ханган ажилласан. 				

Төлөвлөгөөний биелэлт боловсруулсан: 

П.Шинэзул /Хуульч/

Хянасан:



Э.Ванчинхүү /Захиргаа, удирдлагын газрын дарга/